

ЗГМ: ЗОЧИН

## Монголчуудын хэрэглэдэг зүйлийг Японд борлуулах амаргүй

Г.Байгал

@baigalZGM

*Япон улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Масато Такаока манай сонины зочноор уригдлаа. Японы гадаад харилцааны албанд 30 орчим жил зүтгэж буй энэ эрхэм Монголд суух Элчин сайдаар томилогдохоосоо өмнө Ирак дахь Японы ЭСЯ, Австралийн Сидней хотод Ерөнхий консулаар ажиллаж байжээ. Манай улсад Итгэмжит жуух бичгээ өргөн барьж, Элчин сайдын албыг хашиад жил хагасыг үдэж буй тэрбээр Монгол, Японы Стратегийн түншлэлийг илүү өргөжүүлэн хөгжүүлэхэд хичээн зүтгэж буй юм.*

**-Бидэнд цаг гаргасан эрхэм Элчин сайд танд баярлалаа. Монгол, Японы харилцаа, хамтын ажиллагааны нэрийн хуудас болсон Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хэрэгжиж эхэлсний хоёр жилийн ой хэзээ мөдгүй тохиох гэж байна. Хоёр жилийн ойн босгон дээрээс эргэн харвал энэ хэлэлцээр манай хоёр улсад эерэг үр дүн авчрав уу?**

-“Засгийн газрын мэдээ” сонинд хэдэн сарын өмнө хэвлэгдсэн нийтлэлд Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хүссэн үр дүнд хүрээгүй талаар хөндсөн байсан.